



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/76

Жаргалтхаан сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 16 дугаар зүйлийн 16.8.6, 16.9.2 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, Сангийн Сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд бог малын хээлтүүлэгчийн үзлэг, ангилалт хийх, ашиг шимийг тогтоох, ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд бог малын ээмэг худалдан авахад зориулж 390,000 (гурван зуун ерэн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 390,000 (гурван зуун ерэн мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Т.Энхсайхан нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ